



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДОА-2022/95/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Чойбалсан хот  
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул  
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn  
Аудитын менежер: И.Сэмжидмаа  
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Нармандах  
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn  
Аудитор: Ч.Удвалноров  
Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	13
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хүрэн сум 7-р баг  
ЗДТ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.02.25 № 191  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОД АЙМГИЙН ХӨГЖИМТ  
ДРАМЫН ТЕАТРЫН ДАРГА  
Л.НАРАНХҮҮ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020039

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>I</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>306,035,992.00</b>	<b>415,359,072.00</b>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	1,702,920.00	
335	Бусад авлага	1,702,920.00	
3351	Байгууллагаас авах авлага	1,702,920.00	
34	УРЬДЧИЛГАА		
35	БАРАА МАТЕРИАЛ	304,333,072.00	415,359,072.00
351	Түүхий эд материал	180,125,259.00	224,960,259.00
3511	Тусгай зориулалттай материал	180,125,259.00	224,960,259.00
353	Бэлэн бүтээгдэхүүн	3,330,000.00	42,930,000.00
354	Хангамжийн материал	114,537,813.00	139,178,813.00
3541	Бичиг хэргийн материал	2,919,200.00	2,964,200.00
3542	Аж ахуйн материал	102,190,763.00	126,786,763.00
3547	Бусад хангамжийн материал	9,427,850.00	9,427,850.00
356	Мал амьтад	6,340,000.00	8,290,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
<b>II</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,433,421,998.72</b>	<b>4,279,597,823.41</b>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,433,421,998.72	4,279,597,823.41
392	Биет хөрөнгө	4,062,006,998.72	3,908,182,823.41
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,862,176,418.00	3,896,592,518.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-173,176,381.94	-247,359,390.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	41,000,000.00	41,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-36,000,000.12	-39,333,333.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	122,645,982.00	127,643,782.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,487,268.72	-94,362,391.25
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	216,090,090.00	216,090,090.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-128,281,125.79	-154,923,640.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	580,127,717.00	580,127,717.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-345,088,431.71	-417,292,527.75
393	Биет бус хөрөнгө	371,415,000.00	371,415,000.00
39301	Програм хангамж	200,000.00	200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-200,000.00	-200,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	371,415,000.00	371,415,000.00
<b>III</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>4,739,457,990.72</b>	<b>4,694,956,895.41</b>
<b>IV</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,702,920.00</b>	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,702,920.00	
413	Өглөг	1,702,920.00	
4136	Бусад өглөг	1,702,920.00	
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,702,920.00	
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
<b>V</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,737,755,070.72</b>	<b>4,694,956,895.41</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,737,755,070.72	4,694,956,895.41
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,887,642,298.00	4,887,642,298.00
51101	Өмч: - төрийн	4,887,642,298.00	4,887,642,298.00

512	Хуримтлагдсан үр дүн	-305,690,060.35	-348,488,235.66
5121	Өмнөх үеийн үр дүн	-305,690,060.35	-305,690,060.35
5122	Тайлант үеийн үр дүн		-42,798,175.31
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	155,802,833.07	155,802,833.07
<b>VI</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>4,739,457,990.72</b>	<b>4,694,956,895.41</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,202,118,720.00</b>	<b>1,194,276,500.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,594,220.00	49,087,600.00
120	Нийтлэг татварын бус орлого	133,594,220.00	49,087,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133,594,220.00	49,087,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	133,594,220.00	49,087,600.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,068,524,500.00	1,145,188,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,260,000.00	81,551,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,550,000.00	71,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,710,000.00	9,651,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,022,264,500.00	1,063,637,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,022,264,500.00	1,063,637,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,185,524,884.92</b>	<b>1,230,484,675.31</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,185,524,884.92	1,230,484,675.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,117,639,683.67	1,097,628,968.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,499,932.75	711,896,579.86
210101	Үндсэн цалин	721,499,932.75	646,893,251.01
210102	Нэмэгдэл		65,003,328.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,299,507.00	91,400,662.00
210201	Тэтгэврийн даатгал	61,403,666.00	63,276,997.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,566,096.00	5,624,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,223,960.00	7,030,915.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,444,790.00	1,406,184.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,660,995.00	14,061,833.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,900,039.00	22,693,877.00
210301	Гэрэл, цахилгаан	5,132,169.00	6,680,000.00
210302	Түлш, халаалт	13,053,659.00	13,082,356.00
210303	Цэвэр, бохир ус	3,714,211.00	2,931,521.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,131,726.00	9,957,035.00
210401	Бичиг хэрэг	1,678,500.00	1,755,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	5,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,814.00	1,302,035.00

210404	Ном, хэвлэл	1,501,520.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,416,642.00	1,200,000.00
210408	Бараа материал акталсны зардал	12,148,250.00	
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,727,900.00	23,491,939.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	363,200.00	857,400.00
210604	Урсгал засвар	47,364,700.00	22,634,539.00
2107	Томилолт, зочны зардал	290,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	290,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,183,047.00	39,900,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	28,985,681.00	37,986,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	315,400.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,666.00	108,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,572,776.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	182,607,531.92	196,788,075.31
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		3,550,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	182,607,531.92	193,238,075.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,885,201.25	132,855,707.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,693,100.00	123,501,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,730,000.00	1,790,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,963,100.00	121,711,300.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,192,101.25	9,354,407.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,192,101.25	9,354,407.14
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>16,593,835.08</b>	<b>-36,208,175.31</b>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,045,000.00	6,590,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	9,045,000.00	6,590,000.00
<b>IV</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-9,045,000.00</b>	<b>-6,590,000.00</b>
<b>V</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>7,548,835.08</b>	<b>-42,798,175.31</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,887,642,298.00	155,802,833.07	-305,690,060.35	4,737,755,070.72
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				

4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
8	Тайлант үеийн үр дүн			-42,798,175.31	-42,798,175.31
9	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>4,887,642,298.00</b>	<b>155,802,833.07</b>	<b>-348,488,235.66</b>	<b>4,694,956,895.41</b>

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,068,524,500.00	1,145,188,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,068,524,500.00	1,145,188,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,260,000.00	81,551,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,550,000.00	71,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	28,710,000.00	9,651,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,022,264,500.00	1,063,637,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,022,264,500.00	1,063,637,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,068,524,500.00	1,145,188,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,068,524,500.00	1,145,188,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,001,169,298.75	1,014,123,192.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	721,499,932.75	711,896,579.86
210101	Үндсэн цалин	600,361,486.89	604,757,243.23
210102	Нэмэгдэл	121,138,445.86	107,139,336.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,299,507.00	91,400,662.00
210201	Тэтгэврийн даатгал	61,403,666.00	63,276,997.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,779,169.00	5,624,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,223,960.00	7,030,915.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,444,790.00	1,406,184.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,447,922.00	14,061,833.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,900,039.00	22,693,877.00
210301	Гэрэл, цахилгаан	5,132,169.00	6,680,000.00
210302	Түлш, халаалт	13,053,659.00	13,082,356.00
210303	Цэвэр, бохир ус	3,714,211.00	2,931,521.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,865,314.00	10,002,035.00
210401	Бичиг хэрэг	1,678,500.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	5,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,186,814.00	1,302,035.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,200,000.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,577,670.00	40,164,539.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,241,870.00	4,997,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	857,400.00
210604	Урсгал засвар	51,035,800.00	34,309,339.00
2107	Томилолт, зочны зардал		1,500,000.00
210702	Дотоод албан томилолт		1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	78,026,836.00	124,915,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,829,470.00	123,001,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	315,400.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	450,666.00	108,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,158,300.00	1,572,776.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		11,550,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		11,550,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	67,355,201.25	131,065,707.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,163,100.00	121,711,300.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,200,000.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,963,100.00	121,711,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,192,101.25	9,354,407.14
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,192,101.25	9,354,407.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,063,637,900.00</b>	<b>1,054,283,492.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,063,637,900.00</b>	<b>1,063,637,900.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	941,926,600.00	932,572,192.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	715,488,000.00	711,896,579.86
210101	Үндсэн цалин	607,428,000.00	604,757,243.23
210102	Нэмэгдэл	108,060,000.00	107,139,336.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,345,400.00	91,400,662.00
210201	Тэтгэврийн даатгал	65,846,200.00	63,276,997.00

210202	Тэтгэмжийн даатгал	5,899,900.00	5,624,733.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,374,900.00	7,030,915.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,475,000.00	1,406,184.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,749,400.00	14,061,833.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,480,000.00	22,693,877.00
210301	Гэрэл, цахилгаан	6,200,000.00	6,680,000.00
210302	Түлш, халаалт	15,000,000.00	13,082,356.00
210303	Цэвэр, бохир ус	3,280,000.00	2,931,521.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,020,000.00	10,002,035.00
210401	Бичиг хэрэг	1,800,000.00	1,800,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,200,000.00	5,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.00	1,302,035.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,200,000.00
2105	Нормативт зардал		
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,167,400.00	40,164,539.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,997,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	857,400.00	857,400.00
210604	Урсгал засвар	34,310,000.00	34,309,339.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,500,000.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,925,800.00	54,914,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,000,000.00	53,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	120,000.00	108,724.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	1,572,800.00	1,572,776.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,711,300.00	131,065,707.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	121,711,300.00	121,711,300.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	121,711,300.00	121,711,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		
	Дотоод эх үүсвэрээр		
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,063,637,900.00</b>	<b>1,054,283,492.86</b>
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,063,637,900.00	1,054,283,492.86
132001	Орон нутгийн төсвөөс	1,063,637,900.00	1,054,283,492.86
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		
124	БУСАД ЭХ ҮҮСВЭР		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
1	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ		
2	БАЙГУУЛЛАГЫН ТОО		
5	АЖИЛЛАГСАДЫН ТОО		79
6	Удирдах ажилтан		1
7	Гүйцэтгэх ажилтан		63
8	Үйлчлэх ажилтан		15

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>81,551,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>81,551,000.00</b>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	81,551,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	70,001,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	70,001,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,550,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,550,000.00
<b>1</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>81,551,000.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	81,551,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	71,900,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,651,000.00
	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл нь уран бүтээлчдийн мэргэжлийн өндөр ур чадварт тулгуурлан үндэсний болон дэлхийн шилдэг, сонгодог урлагийн бүтээлээр иргэдэд хүртээмжтэй үйлчлэх, хүн амын гоо зүй, урлагийн мэдрэмжийг хөгжүүлэх, төлөвшүүлэх, авьяасыг нээн, урлагийн боловсрол олгох чиглэлээр нийгэмд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулах, орон нутгийн соёл урлагийн онцлог,

агуулгатай, уран бүтээл/брэнд/-ийг бий болгож улсын болон олон улсын түвшинд гаргаж таниулах.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага нь хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын нэгжгүй бөгөөд хяналтыг санхүүгийн албаны дарга хэрэгжүүлэн ажилладаг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,796.5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 17.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 12.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Бараа материалын дансны үлдэгдэл 415.4 сая төгрөг болж 111.4 сая төгрөгөөр өссөн нь тусгай зориулалттай материал, бэлэн бүтээгдэхүүн, аж ахуйн материалын өсөлттэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,233.1 сая төгрөг болж 39.4 сая төгрөгөөр өссөн нь барилга, байгууламж, орон сууц, машин тоног төхөөрөмжийн өсөлтөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данс нь төсвийн хөрөнгийн худалдан авалтаар 5.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 8.9 сая төгрөгийн барилга, байгууламж, орон сууц, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 25.5 сая төгрөгийн барилга, байгууламж, орон сууцаар нэмэгдсэн байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 7.8 сая төгрөгөөр буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлоготой холбоотой байна. Нийт зардал өмнөх оноос 44.9 сая төгрөгөөр өссөн нь бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал зэргээс шалтгаалсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,063.6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,063.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,063.6 сая төгрөгийн төсөв баталснаас 1,063.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,063.6 сая төгрөгийн санхүүжилт авч төсвийн нийт зардлын гүйцэтгэл 99.1 хувь буюу 1,054.1 сая төгрөг, буцаан төвлөрүүлсэн 0.9 хувь буюу 9.4 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 9.7 сая төгрөгийг төвлөрүүлж, дээд шатны төсвийн захирагчаас 71.9 сая төгрөг, нийт 81.6 сая төгрөг байна. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 70.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 11.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дорнод аймгийн Хөгжимт драмын театр нь 2021 онд нийт 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн хугацаанд 148 мэдээллийг бүрэн мэдээлж, 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 29.6 сая төгрөгийн 2 албан шаардлага, 1.4 сая төгрөгийн 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар захиргааны хэм хэмжээгээр тогтоосон тогтоол, журмуудыг мөрдөж ажиллаж байгаа эсэхийг анхаарч үзэх.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 11.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Тайлант хугацаанд залруулсан алдаа байхгүй болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Тайлант хугацаанд төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### **4.3 Албан шаардлага**

1. Бараа материалын тооллогоор аж ахуйн материал 0.3 сая төгрөгөөр илүү, бусад хангамжийн материал 0.4 сая төгрөгөөр дутуу, мал амьтад 0.7 сая төгрөгөөр дутуу бүртгэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Төсвийн хөрөнгөөс Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;” гэж заасны дагуу батлагдсан төсвийн зардлын дүнд 10.5 сая төгрөгийн хэмнэлттэй байхаар удирдан зохион байгуулж ажиллаагүй байна.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Шилэн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд Шилэн дансны сайтад 1 мэдээлэл хуулийн хугацаа хоцроон мэдээлсэн.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заасны дагуу мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дорнод аймгийн Хөгжимт драмын театр	3	11.8	-	-	-	-	2	11.8	1	-